



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны албан ажлын хэрэгцээнд зориулан нийт 75,800,000.00 (далан таван сая найман зуун мянган) төгрөгөөр автомашиныг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000063

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн
44... дугаар тогтоолын хавсралт



Сангийн яамны олж авах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын, хөдөлгүүрийн багтаамж 3500 cc хүртэл, суудлын тоо 12	75,800,000.00	1	75,800,000.00
	Нийт дүн		1	75,800,000.00 (далан таван сая найман зуун мянган)